

**Аймгийн удирдах ажилтнуудын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2024.03.01

Чойр Хот

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	<p>Үндэсний судалгааны нэгдсэн сан болох www.sudalгаа.gov.mn цахим платформд байршуулах 2023 онд төрийн байгууллагын захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтний garamsuren.b@govisumber.gov.mn хаягт ирүүлэх</p>	2024.03.04	<p>Үндэсний судалгааны нэгдсэн сан болох www.sudalгаа.gov.mn цахим платформд байршуулах 2023 онд төрийн байгууллагын захиалгаар хийгдсэн судалгаа 1 байна. Үүнд: Боловсролын судалгааны Үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газрын Насан туршийн боловсролын хэлтэстэй хамтран 0-18 насны хүүхдийн сургуульд завсардсан шалтгааныг илрүүлэх судалгааг аймгийн хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Судалгааг одоогоор цахим платформд байршуулаагүй, засвар хийгдэж байна.</p>	70
2	<p>Малын сэг зэм, хог хаягдал устган цэвэрлэх ажлын төсвийн тооцоог гаргаж, холбогдох байгууллагууд бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж хамтарч ажиллах</p>	2024.03.04	<p>Сүмбэр сумын Засаг даргын 2024 оны 02 сарын 15-ны өдрийн А/56 дугаар захирамжаар “Ариутгал халдваргүйжүүлэлт, сэг зэм устгах ажилд хяналт тавих” ажлын хэсгийг байгуулан сэг зэм цуглуулах болон ариутгал халдваргүйжүүлэлт хийх, устгах байршил цэгийг тогтоон, аймгийн мал эмнэлгийн газарт төлөвлөгөө болон шаардлагатай төсөв, хүн хүч, машин техникийн судалгааг гарган хүргүүлсэн. Шивээговь сум 2024 оны 2 дугаар сарын 9 болон 19-ний өдөр Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсэг, Страто ХХК-тай хамтран улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу, сумын төвийн ойр орчим, 21-р зөрлөгийн орчимд 445 малын сэг зэмийг цуглуулан 40 кг бодисоор халдваргүйжүүлэн булж устгав. Баянтал сумын хэмжээнд нийт сэг зэмийг бөөгнүүлэх, устгах маршрут гарган 2 цэгийг тогтоогоод байна.</p>	50

3	Өвс, тэжээлийн нөөцийг хуулийн хүрээнд бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, худалдан авалтыг яаралтай зохион байгуулах	2024.03.04	<p>Аймгийн аюулгүйн нөөцөд даргын нөөц хөрөнгөөс 134.2 сая төгрөгөөр 49.3 тонн өвс, 100 тонн тэжээл худалдан авсан.</p> <p>Сүмбэр сум Пример Агро ХХК-аас хорголжин тэжээл 850.0 мянган төгрөг, Тэжээлийн хивэг 800.0 мянган төгрөг, Орос овьёос 1100.0 мянган төгрөгийн дүнгээр худалдан авах санал ирснийг малчдад хүргүүлсэн. 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөс 45,5 сая төгрөг, 2023 оны нөөц хөрөнгөөс 6.2 сая төгрөгөөр аюулгүйн нөөц бүрдүүлэхээр худалдан авах ажилгааг зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>Шивээговь суманд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхээр ОНХС-аас 74.0 сая төгрөгөөр шууд худалдан авалтыг зарлаж, 3 аж ахуй нэгжид үнийн санал хүргүүлээд байна.</p> <p>Баянтал суманд аймгийн нөөцөөс 14 тонн өвс олгосон. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 7.0 сая төгрөгөөр 7 тонн өвс худалдан авсан.</p>	70
Дундаж хэрэгжилт				63.3

Хянасан:

ХШҮХ-ийн дарга

М.Анхбаяр

Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:

ХШҮХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхзаяа